



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 4 дүгээр
сарын 6-ны өдөр

Дугаар 141

Улаанбаатар
хот

Засгийн газрын 2022 оны зээллэгийн
төлөвлөгөө батлах тухай

Өрийн удирдлагын тухай хуулийн 8.1.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Засгийн газрын 2022 оны зээллэгийн төлөвлөгөө”-г хавсралт ёсоор баталсугай.

2. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хүрээнд төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд үүрэг болгосугай.




Монгол Улсын Ерөнхий сайд

Сангийн сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.ЖАВХЛАН



Засгийн газрын 2022 оны 141 дүгээр
тогтоолын хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ ЗЭЭЛЛЭГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 55 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль болон Өрийн удирдлагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтыг үндэслэн энэхүү зээллэгийн төлөвлөгөөг боловсруулав.

1.Засгийн газрын 2022 оны санхүүжилтийн хэрэгцээ

1.1.Монгол Улсын 2022 оны Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2,387.1 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар батлагдсан.

1.2.Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн дүнг оруулан тооцсоноор Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ 2022 онд 3,884.1 тэрбум төгрөг байна.

1.3.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд Тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2022 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын гадаад, дотоод зээллэгийн үндсэн төлбөрийн хэмжээ 3,099.6 тэрбум төгрөг байхаар зааснаас 2021 онд гаргахаар төлөвлөсөн дотоод үнэт цаасны 2022 онд төлөхөөр төлөвлөсөн үндсэн төлбөрийн хэмжээгээр буурч 1,497.0 тэрбум төгрөг болохоор байна.

1.4.Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээний 1,617.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг Засгийн газрын гадаад төсөл, хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээлээр, 2,123.7 тэрбум төгрөг хүртэл эх үүсвэрийг Засгийн газрын дотоод үнэт цаас арилжаалан бүрдүүлэхээр тооцоолсон.

1.5.Гадаад зээл, гадаад үнэт цаас, дотоод үнэт цаас зэрэг өрийн хэрэгслийн цэвэр өөрчлөлт Хүснэгт 1-д заасны дагуу 2,243.7 тэрбум төгрөг ба барих-шилжүүлэх нөхцөлтэй концесс, Засгийн газрын өрийн баталгааны цэвэр өөрчлөлт болон ханшийн өөрчлөлтийг тооцсоноор Зээллэгийн төлөвлөгөөний 3.2-т заасны дагуу Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан Засгийн газрын өр нэмэгдүүлэх дээд хэмжээнд нийцэхээр байна.

1.6.Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэрийн задаргааг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1: Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ, өрийн хязгаар

№	Санхүүжилтийн хэрэгцээ	Дүн (тэрбум төгрөг)
1.	Тэнцвэржүүлсэн орлого ба тусламж	15,771.7

2.	Нийт зарлага ба цэвэр зээл	18,158.8
3.	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл (1-2)	2,387.1
4.	Дотоод үндсэн төлбөр	291.6
5.	Гадаад үндсэн төлбөр	1,205.4
6.	Нийт санхүүжилтийн хэрэгцээ (3+4+5)	3,884.1
	<i>Санхүүжүүлэх эх үүсвэр</i>	
6.1.	Гадаад төслийн зээлээр санхүүжих	1,324.0
6.2.	Гадаад хөтөлбөрийн зээлээр санхүүжих	293.0
6.3.	Дотоод үнэт цаасны гаргалт	2,123.7
6.4.	Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл болон тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдлээс санхүүжих	143.4
7.	Алдагдал санхүүжүүлэх өрийн хэрэгслийн цэвэр өөрчлөлт (6.1+6.2+6.3-4-5)	(2,243.7)

2.Засгийн газрын 2022 онд шинээр хийх зээллэгийн төлөвлөгөө

Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн хүрээнд 2022 онд шинээр хийх зээллэгийг өрийн хэрэгсэл тус бүрээр тодорхойлов.

2.1.Дотоод үнэт цаас

2.1.1.Засгийн газар Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3-12.1.4 дэх заалтад заасан зориулалтын дагуу нийт 2,123.7 тэрбум төгрөг хүртэлх дотоод үнэт цаас гаргана;

2.1.2.Засгийн газар Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т заасан зориулалтаар гаргах үнэт цаасны хэмжээ нь тухайн оны төсвийн улирлын чанартай орлогын дутагдлын хэмжээ болон тухайн оны батлагдсан хүүгийн зардлаар хязгаарлагдана;

2.1.3.Засгийн газрын 2022 онд шинээр гаргах дотоод үнэт цаасны төлөвлөгөөг доорх хүснэгтэд харуулав;

Хүснэгт 2: Засгийн газрын 2022 онд гаргах дотоод үнэт цаасны төлөвлөгөө

№	Дотоод үнэт цаасны зориулалт	Үнэт цаасны төрөл (хугацаагаар)	Гаргах боломжит хугацаа	Гаргах дээд хэмжээ (тэрбум төгрөг)	Улирлын гаргах дээд хэмжээ (тухайн зориулалтын дагуу гаргах дээд хэмжээний хувь, өссөн дүнгээр)
1.	Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх (ӨУТХ 12.1.1)	Богино хугацаат	3 сар, 6 сар, 9 сар, 1 жил	1,097.2	II улирал - 35% III улирал - 60% IV улирал - 100%
		Дунд, урт хугацаат	2 жил, 3 жил, 5 жил, 10 жил	601.7	
		Нийт		1,698.9	

2.	Төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх (ӨУТХ 12.1.2)	Богино хугацаат	3 сар, 6 сар, 9 сар	Төсвийн улирлын чанартай мөнгөн хөрөнгийн дутагдлаас хамаарах бөгөөд тухайн оны батлагдсан хүүгийн зардлаар хязгаарлагдана.	II улирал - 50% III улирал - 100%
3.	Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжих (ӨУТХ 12.1.3)	Богино, дунд, урт хугацаат	3 сараас 10 жил хүртэл	нэг удаагийн арилжаанд 6.0 тэрбум төгрөг хүртэл 191.2	II улирал - 33% III улирал - 66% IV улирал - 100%
4.	Өрийг дахин санхүүжүүлэх (ӨУТХ 12.1.4)	Богино, дунд, урт хугацаат	3 сараас 10 жил хүртэл	233.6	II улирал - 50% III улирал - 75% IV улирал - 100%

2.1.4.Засгийн газрын дотоод үнэт цаасыг энэхүү зээллэгийн төлөвлөгөө болон “Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журам”, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн 87 дугаар тогтоолд тус тус нийцүүлэн нээлттэй болон хаалттай хэлбэрээр арилжаална;

2.1.5.Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2022 онд нэмэгдэх дээд хэмжээ 1,832.1 тэрбум төгрөг байна.

2.2.Гадаад үнэт цаас

2.2.1.“Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”-т заасны дагуу гадаад үнэт цаасыг зөвхөн дахин санхүүжүүлэх зорилгоор гаргах бөгөөд гадаад зах зээлийн нөхцөл байдал, зардал эрсдэлийн судалгааг хийсний үндсэн дээр гадаад үнэт цаасыг хугацаанаас өмнө буцаан худалдан авах, дахин санхүүжүүлэх арга хэмжээг авч болно;

2.2.2.Засгийн газар өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд олон улсын зах зээлд арилжаалах гадаад үнэт цаасны дээд хэмжээ 0.5 тэрбум ам.доллар байх бөгөөд гадаад үнэт цаас арилжаалах үйл ажиллагааг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, Өрийн удирдлагын тухай хуулийн 20.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн 87 дугаар тогтоолыг үндэслэн тухай бүр Сангийн сайдын тушаалаар авч хэрэгжүүлнэ;

2.2.3.Засгийн газрын гаргах гадаад үнэт цаасны мэдээллийг доорх хүснэгтэд харуулав;

Хүснэгт 3: Засгийн газрын 2022 онд гаргах гадаад үнэт цаасны төлөвлөгөө

№	Дотоод үнэт цаасны зориулалт	Гадаад цаасны төрөл (хугацаагаар)	Гаргах боломжит хугацаа	Гаргах дээд хэмжээ	Арилжаалах улирал
1.	Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх (ӨУТХ 12.1.1)	-	-	-	-
2.	Өрийн дахин санхүүжүүлэх (ӨУТХ 12.1.4)	Дунд болон урт хугацаат	5-30 жил хүртэл	0.5 тэрбум ам.доллар	Зах зээлийн нөхцөл байдал, зардал эрсдэлийн шинжилгээнд үндэслэн тогтооно.
3.	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санхүүжүүлэх (ӨУТХ 12.1.5)	-	-	-	-
4.	Гадаад валютын цэвэр албан нөөцийг нэмэгдүүлэх. (ӨУТХ 12.1.6)	-	-	-	-

2.2.4.Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 2022 онд хамгийн багадаа 171.2 тэрбум төгрөгөөр буурахаар байна.

2.3.Гадаад зээл

2.3.1.Засгийн газар гадаад хөнгөлөлттэй зээлийн гэрээ хэлэлцээрийн хүрээнд 1,324.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй төслийн зээл, 293.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй хөтөлбөрийн зээлийг олон улсын байгууллага, хоёр болон олон талт хөгжлийн түншүүдээс авч ашиглана;

2.3.2.Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн задаргааг доорх хүснэгтээр харуулав;

Хүснэгт 4: Засгийн газрын 2022 онд шинээр ашиглах гадаад зээлийн төлөвлөгөө

№	Зээлдүүлэгч улс/ байгууллага	Зээлдүүлэгч банк/ байгууллага	Гэрээ байгуулагдсан огноо	Хугацаа	Хүү	Дүн (сая ₮)
1. Нэн хөнгөлөлттэй зээл						164,457.50
1.	Бүгд Найрамдах Австри Улс	Raiffessen банк, UniCredit банк	2016.09.27- шинээр байгуулах	18 жил	0.00%	20,506.00
2.	Азийн хөгжлийн банк	Азийн хөгжлийн банк	2018.12.26- шинээр байгуулах	25-40 жил	0.25%, 2.00%, Libor+0.60 %	29,851.00

3.	Бүгд Найрамдах Солонгос Улс	БНСУ-ын ЭКСИМ банк	2012.05.17-шинээр байгуулах	30-40 жил	0.00%-0.20%	55,188.50
4.	Бүгд Найрамдах Франц Улс	Натиксис банк	2008.06.05-шинээр байгуулах	25-40 жил	0.01%-0.90%	14,229.00
5.	Бүгд Найрамдах Энэтхэг Улс	БНЭУ-ын ЭКСИМ банк	2012.02.14	25 жил	0.75%	14,600.0
6.	Бүгд Найрамдах Польш Улс	БНПУ-ын Засгийн газар	2017.06.09-шинээр гэрээ байгуулах	28 жил	0.15%	6,336.00
7.	Унгар Улс	БНУУ-ын ЭКСИМ банк	2016.01.25	17.5 жил	0.00%	10.00
8.	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	ХБНГУ-ын Сэргээн босголт, хөгжлийн банк	2007.12.21-шинээр гэрээ байгуулах	30 жил	2.00%	1,890.00
9.	Япон улс	Япон улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага	2014.03.12	20 жил	0.20%	21,847.00
2. Хөнгөлөлттэй зээл						1,060,112.50
1.	Азийн хөгжлийн банк	Азийн хөгжлийн банк	2011.01.27-шинээр байгуулах	18-25 жил	2.00%, Libor+0.50 %	461,577.50
2.	Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк	Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк				29,910.00
3.	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	БНХАУ-ын ЭКСИМ банк	2014.08.21-шинээр байгуулах	20 жил	2.00%	249,319.00
4.	Бүгд Найрамдах Энэтхэг Улс	БНЭУ-ын ЭКСИМ банк	2016.04.28	25 жил	1.75%	140,000.00
5.	Бүгд Найрамдах Беларусь Улс	БНБУ-ын хөгжлийн банк	2020.07.31	6 жил	0.38%	6,208.00
6.	Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци, Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк	Дэлхийн банк	2015.07.31-шинээр байгуулах	25 жил	1.88%-2.00%	142,688.00
7.	Европын хөрөнгө оруулалтын	ЕХОБ	2014.06.30	25 жил	Libor	25,010.00

	банк					
8.	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан	ХААХОУС	2017.06.09	25 жил	2.00%	5,400.00
3. Арилжааны зээл						99,430.00
1.	Европын сэргээн босголт, хөгжлийн банк	ЕСБХБ	2018.09.05	15-18 жил	Libor+1.00%	99,430.00
	Нийт					1,324,000.0

2.3.3.Засгийн газрын 2022 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 62 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын Засгийн газрын хувьсагч хүүтэй гадаад зээлүүдийн суурь хүү болох Лондонгийн банк хоорондын хүү /ЛИБОР/-г дэлхий даяар хэрэгсэхгүй болж буйтай холбогдуулан шинээр мөрдөгдөх хүүгийн түвшинг зээлдүүлэгчидтэй зөвшилцөх замаар шийдвэрлэх, Засгийн газрын өрийн багц дахь хувьсах хүүтэй гадаад зээлийг зардал, эрсдэлийн судалгаагаар ашигтай нөхцөлд тогтмол хүүтэй зээлд шилжүүлнэ;

2.3.4.Засгийн газрын гадаад төслийн зээлийн үлдэгдэл 2022 онд нэмэгдэх дээд хэмжээ 1,308.1 тэрбум төгрөг байна.

2.4.Засгийн газрын өрийн баталгаа

2.4.1.Засгийн газрын зүгээс 2022 онд Дорнод аймгийн Матад сумаас Дорноговь аймгийн Алтанширээт сумд байршилтай Газрын тос боловсруулах үйлдвэр хүртэлх “Газрын тос дамжуулах хоолой”-н санхүүжилтэд 1,465.0 тэрбум төгрөг, “Тавантолгойн цахилгаан станц”-ын бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтэд 1,657.8 тэрбум төгрөг хүртэлх шинээр өрийн баталгаа гаргаж болно;

2.4.2.Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2022 онд 3,046.1 тэрбум төгрөг хүртэл өснө;

2.4.3.Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл болон шинээр гаргах дээд хэмжээ нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиудтай нийцсэн байна.

2.5.“Барих-шилжүүлэх” төрлийн концессын гэрээ

2.5.1.Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн Зорилт 4-т заасны дагуу Засгийн газар “барих-шилжүүлэх” төрлийн концессын гэрээ шинээр байгуулахгүй.

3.Бусад

3.1.Зээллэгийн төлөвлөгөөний дагуу зээллэг хийснээр Засгийн газрын өрийн багцын үзүүлэлтүүд дараахь түвшинд хүрэхээр төсөөлөлтэй байгаа нь “Засгийн газрын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”-т заасан зорилтот үзүүлэлтүүдтэй нийцэж байна.

Хүснэгт 4: Засгийн газрын өрийн багцын үзүүлэлтүүд

Засгийн газрын өрийн багцын үзүүлэлт	2022 оны зорилтот хэмжээ		2022 онд хүлээгдэж буй гүйцэтгэл
	Дээд	Доод	
Жигнэсэн дундаж хүү (хувь)	Дээд	3.6	3.0
	Доод	3.4	
Засгийн газрын өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа (жил)	Дээд	8.6	8.3
	Доод	8.0	
Засгийн газрын өрийн хүү шинэчлэгдэх дундаж хугацаа (жил)	Дээд	8.4	7.6
	Доод	7.4	
Гадаад валютаар илэрхийлсэн өр (нийт өрд эзлэх хувь)	Доод	86.0 хувь	90 хувь

3.2. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлд “Засгийн газрын нэмэгдүүлэх өр болон өрийн баталгааны дээд хэмжээ 2022 оны төсвийн жилд 5,849,421.3 сая төгрөг байна” гэж заасантай Зээллэгийн төлөвлөгөөний 2.1.5, 2.2.4, 2.3.4, 2.4.2, 2.5.1 дэх зохицуулалтууд нийцэж байна.

3.3. Зээллэгийн төлөвлөгөөний 2.1.5, 2.2.4, 2.3.4, 2.4.2, 2.5.1 дэх заалтуудад заасан өрийн хэрэгслийн үлдэгдэл нэмэгдэх хэмжээ гадаад валютын ханшийн өөрчлөлт, “барих-шилжүүлэх” төрлийн концессын гэрээгээр хэрэгжиж байгаа төслийн гүйцэтгэлээс шалтгаалан хэтрэхээр байгаа тохиолдолд Засгийн газрын дотоод үнэт цаасны гаргалт, гадаад хөнгөлөлттэй зээлийн ашиглалтад зохицуулалт хийх замаар Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан дээд хэмжээнд нийцүүлж болно.

3.4.Зээллэгийн төлөвлөгөөний 2.3.2 дахь заалтад заасан гадаад хөнгөлөлттэй зээлийн ашиглалтыг дүнг тухайн хөгжлийн түнш байгууллагын санхүүжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт болон бусад зайлшгүй нөхцөл байдлыг харгалзан, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар батлагдсан нийт дүнд багтаан Төсвийн тухай хуулийн дагуу шилжүүлэн, зохицуулалт хийж болно.